



## ЮНЕСКО-ийн дэлхийн геопаркуудын сүлжээнд нэгдэхээр төлөвлөж буй газруудад бие даан үнэлгээ хийхэд зориулсан маягт

Индонезийн Ломбок хотноо (2019 оны 9-р сард) болсон ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын зөвлөлийн 4-р хурлаар ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын үйл ажиллагааны удирдамжид заасан ёсоор ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын сүлжээнд нэгдэхээр төлөвлөж буй газруудад бие даан үнэлгээ хийхэд зориулсан маягтыг боловсруулж, эцэслэхээр шийдвэрлэсэн.

**Энэхүү маягт нь 101 асуултаас бүрдэх бөгөөд эдгээр асуултуудыг ашиглан** геопарк болохоор төлөвлөж буй газарт бие даан үнэлгээ хийх боломжтой юм. Эдгээр 101 асуултыг ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын үйл ажиллагааны удирдамжийн 3(viii)-р хэсэгт тусгасан ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын сүлжээнд нэгдэхээр төлөвлөж буй газар (цаашид “геопарк болохоор төлөвлөж буй газар” хэмээх)-т зориулсан шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан боловсруулсан.

Эдгээр асуултууд болон тэдгээрийн тайлбар нь геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн нөхцөл байдлыг богино хугацаанд хялбар тодорхойлох боломжийг бүрдүүлэх бөгөөд нэр дэвшүүлэх маягт болон үнэлгээний А маягтыг орлохгүй юм. Тиймээс энэхүү бие даан үнэлгээ хийхэд зориулсан маягтыг өргөдлийн маягтад хавсарган ЮНЕСКО-д хүргүүлэх шаардлагагүй болохыг анхаарна уу. Энэхүү маягт нь тухайн улсын дотоод хэрэглээнд зориулагдсан бөгөөд хэрэв хүсэхгүй бол үнэлгээний комисстой энэхүү маягтын талаар ярилцах шаардлагагүй юм.

Энэ маягтыг бөглөхийн тулд асуулт бүр дээрх Тийм эсвэл Үгүй гэсэн хэсгийн аль нэгийг тодруулан тэмдэглэнэ үү. Гэрлэн дохионы өнгө (ногоон/шар/улаан)-ний утгыг ашиглан урьдчилан тодорхойлсон схем нь доор дурдсан шалгууруудын хамт геопарк болохоор төлөвлөж буй газрыг ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын сүлжээнд нэр дэвшихэд бэлэн болсон эсэхийг харуулах болно.

- **Хүснэгтийн ногоон өнгөтэй цонхнууд бүгд бөглөгдсөн:** Геопарк болохоор төлөвлөж буй газрыг нэр дэвшүүлэх нөхцөл сайн бүрдсэн байгааг илтгэнэ;

- **Хүснэгтийн шар өнгөтэй цонхнуудаас 15 хүртэлх цонх нь бөглөгдсөн:** Геопарк болохоор төлөвлөж буй газарт тодорхой сул талууд байгааг харуулж байгаа бөгөөд тус газрыг нэр дэвшүүлсэн тохиолдолд буцаагдах эсвэл татгалзсан хариу авах магадлал өндөртэй болохыг илэрхийлнэ;

- **Хүснэгтийн шар өнгөтэй цонхнуудаас 15-аас дээш тоотой цонх бөглөгдсөн:** Геопарк болохоор төлөвлөж буй газарт олон сул талууд байгааг харуулж байгаа бөгөөд тус газрыг нэр дэвшүүлсэн тохиолдолд татгалзсан хариу авах магадлал өндөр байгааг илэрхийлнэ;

- **Хүснэгтийн улаан өнгөтэй цонхнуудаас хоёр ба түүнээс олон тооны цонх бөглөгдсөн:** Геопарк болохоор төлөвлөж буй газар нь ЮНЕСКО-ийн дэлхийн геопаркуудын үйл ажиллагааны удирдамжид заасан шалгууруудыг биелүүлэхгүй байгааг илтгэх бөгөөд тус газрыг нэр дэвшүүлсэн тохиолдолд татгалзсан хариу авах нь тодорхой байгааг илэрхийлнэ.

Хэд хэдэн асуултад (\*) таних тэмдэг нэмсэн байгаа нь ЮНЕСКО-ийн дэлхийн геопаркуудын зөвлөл өнгөрсөн хугацаанд иймэрхүү ижил төстэй асуудлыг хэрхэн

шийдвэрлэсэн талаарх нэмэлт мэдээлэл, жишээ, зааварчилгааг өгсөн гэдгийг харуулж байгаа юм.

<b>Шалгуур i</b>			
		<b>Тийм</b>	<b>Үгүй</b>
	ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк нь олон улсын геологийн ач холбогдол бүхий газар нутаг, ландшафтуудыг хадгалалт хамгаалалт (iC), боловсрол (iD), судалгаа (iE) болон тогтвортой хөгжлийн (iF) цогц үзэл баримтлалаар удирддаг нэг, нэгдмэл газарзүйн бүс (iA) байх ёстой. ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк нь тодорхой хил хязгаартай (iG) байх ёстой бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээтэй, шинжлэх ухааны мэргэжилтнүүд бие даан баталгаажуулсан олон улсын ач холбогдол бүхий геологийн өвийг агуулсан байх (iH) шаардлагатай.		
	<b>Нэгдсэн нэг газар нутаг (iA)</b>		
1	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь нэгдмэл, нэг нутаг дэвсгэртэй юу?		
	<b>Хил (iG)</b>		
2	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь тодорхой хил хязгаартай юу?		
3 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газрын хил нь тус газрын үндэсний хил хязгаар (өөрөөр хэлбэл засаг захиргаа/улсын хил, тусгай хамгаалалттай газар нутгийн хил гэх мэт)-тай адилхан уу?		
	<b>Тохиромжтой хэмжээ (iH)</b>		
4 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газрын нутаг дэвсгэр нь нэлээд хэмжээний хүн амтай юу?		
5 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газрын нутаг дэвсгэрийн хэмжээ нь орон нутгийн хүн амын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж чадаж байна уу?		
	<b>Геологийн өвийн олон улсын үнэ цэнэ (iB)</b>		
6 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь олон улсын үнэ цэнэтэй геологийн өвтэй болохыг нотлох тодорхой баримт байгаа юу?		
7 (*)	Энэхүү геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн геологийн өвийг танай улсын эсвэл танай улстай хиллэдэг улс орны өөр ЮНЕСКО-ийн геопаркын геологийн өвтэй харьцуулах боломжтой юу? <b>Хэрэв тийм бол 8-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 9-р асуулт руу шилжинэ үү.</b>		
8	Хэрэв тийм бол тус 2 газрын геологийн өвийн ялгаа (болон ижил төстэй байдлыг) -г харуулсан бие даасан геологийн судалгаа хийсэн үү?		
	<b>Хадгалан хамгаалалт (iC)</b>		
9	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь мэдээллийн сан, бүртгэл данстай юу?		
10	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь геологийн өв бүхий газруудыг харуулсан газрын зурагтай юу?		
11	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь геологийн газрын зурагтай юу?		

12	Танай улсын чухал геопарк болохоор төлөвлөж буй газар нутгууд нь хамгаалалтын статусаасаа шалтгаалан тодорхой ашиг тусыг хүртэж байгаа юу?		
13	Зохисгүй хэрэглээ, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх тодорхой журамтай юу?		
14	Эдгээр газруудад засвар үйлчилгээ, цэвэрлэгээ тогтмол хийгддэг үү?		
15 (*)	Хэрэв танай оронд тусгай хамгаалалттай геологи/геоморфологийн эмзэг газрууд байгаа бол эдгээр газруудад элэгдлээс хамгаалах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлдэг үү?		
16	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь соёл, байгалийн өвийн чиглэлээр хадгалан хамгаалагдсан уу?		
	<b>Боловсрол (iD)</b>		
17	Тус газарт геологийн өвтэй холбоотой боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг үү (биологийн бус )?		
18 (*)	Тус газарт (биологийн ) байгалийн өвтэй холбоотой боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг үү?		
19	Тус газарт соёлын болон биет бус өвтэй холбоотой боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг үү?		
20	Тус газарт тодорхой боловсролын хөтөлбөрүүд (тухайлбал сургуулийн өмнөх насны хүүхдүүд, бага, дунд, их сургуулийн оюутнуудад зориулсан) хэрэгжүүлдэг үү?		
21	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь дотроо боловсролын зорилгоор явган аялал хийдэг замтай юу?		
	<b>Боловсролын арга хэрэгсэл</b>		
22	Тус газар нь төрөл бүрийн боловсролын тусгай хэрэгслүүд (хэвлэл, видео, дижитал самбар, интерактив элементүүд, тусгай үзмэрүүд, таавар гэх мэт) -ийг ашигладаг уу?		
	<b>Судалгаа (iE)</b>		
23 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь нутаг дэвсгэртээ судалгаа шинжилгээг дэмжин хөгжүүлдэг үү?		
23бис	Сүүлийн 5 жилд хэвлэгдсэн тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн талаарх шинжлэх ухааны хэвлэл нийтлэл байгаа юу?		
24	Тус газар нутагт хийсэн судалгаанд оролцсон шинжлэх ухааны байгууллага эсвэл их сургууль байгаа юу?		
	<b>Тогтвортой эдийн засгийн хөгжил (iF)</b>		
	<b>Сурталчилгаа , дэд бүтэц, барилга байгууламж</b>		
25 (*)	Тус нутаг дэвсгэрт зочилж буй хүмүүс геопаркт зочилж байгаа гэдгээ амархан таньж, ойлгож байна уу? Геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь тухайн орчинд зохих ёсоор ялгаран харагддаг уу?		
26 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газрын орох хэсэг болон тус газрын чухал хэсгүүдэд мэдээллийн самбар байгаа юу?		
27	Тус геопарк болохоор төлөвлөж буй газарт мэдээлэл өгөх самбар эсвэл бусад систем байгаа юу?		
28	Зам дагуу эсвэл чухал газруудад тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн талаарх самбар, тэмдэг тэмдэглэгээ байгаа юу?		

29	Тус газарт олон нийтийн мэдээллийн дэд бүтэц байгаа юу (өөрөөр хэлбэл тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт сургалт, мэдээллийн төв байгаа юу)?		
30 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт үзэсгэлэнгийн өрөө эсвэл музей байгаа юу?		
31 (*)	Хэрэв тийм бол тус мэдээллийн төв эсвэл музейд буй танилцуулга материалууд англи хэл дээр байдаг уу?		
32	Тус газар нь цахим хуудастай юу?		
33 (*)	Хэрэв тийм бол тус цахим хуудас нь англи хэл дээр байдаг уу?		
34	Тус геопарк болохоор төлөвлөж буй газарт газар нутгаа танилцуулсан танилцуулга, постер, хэвлэл гэх мэт зүйл бий юу?		
35 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт англи хэл дээр хийгдсэн танилцуулга, хэвлэл гэх мэт зүйл байгаа юу?		
36	Тус газарт зочдод үзүүлэхээр зориулсан газруудыг харуулсан газрын зураг байгаа юу?		
37	Геопарк болохоор төлөвлөж буй газрын зочдод үзүүлэхээр зориулсан газруудад машины зогсоол байгаа юу?		
	<b>Түншлэлүүд</b>		
38 (*)	Тус газар нь орон нутгийн холбогдох байгууллагууд (зоогийн газар, зочид буудал гэх мэт) -тай албан ёсны хамтын ажиллагаатай байдаг уу?		
39	Орон нутгийн бүтээгдэхүүн/үйлдвэрлэгчидтэй хамтран тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн брэндийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг үү?		
40	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь түнш байгууллагуудтай хамтын ажиллагааныхаа талаарх харагдах байдал (самбар, постер гэх мэт) -ыг хөгжүүлсэн үү?		
	<b>Геотуризм</b>		
41	Тус газар нь зочид жуулчдад зориулсан сурталчилгааны материалтай юу?		
42	Тус газар нь мэргэшсэн аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран ажилладаг уу?		
43	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь хөтөч нарт эсвэл хамтран ажилладаг аялал жуулчлалын байгууллагуудад зориулсан сургалт явуулдаг уу?		
44	Тус газарт зочдод зориулсан хяналтын систем байгаа юу?		
45	Тус газарт ирэх 4 жилд хэрэгжүүлэх геологийн аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөө байгаа юу?		
<b>Шалгуур ii</b>			
	(ii) ЮНЕСКО-ийн дэлхийн геопарк нь тус газрын геологийн өвийг тухайн нутаг дэвсгэрийн байгалийн болон соёлын өвийн бусад бүх шинж чанаруудтай уялдуулан бидний амьдарч буй динамик ертөнц дэх геологийн үйл явц, аюул занал, уур амьсгалын өөрчлөлт (iiB), дэлхийн байгалийн нөөцийг тогтвортой ашиглах хэрэгцээ шаардлага, амьдралын хувьсал өөрчлөлт, уугуул иргэдийн мэдлэг чадвар (iiC) зэрэгтэй холбоотой нийгэмд тулгарч буй гол асуудлуудын талаарх мэдлэг, ойлголт (iiA) -ыг сайжруулахын тулд ашиглах нь зүйтэй юм.		

	<b>Байгалийн бусад өв -биотик- (iiA)</b>		
46	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь тусгай хамгаалалттай бүс нутгуудыг хамардаг уу? <b>Хэрэв тийм бол: 47- 49-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 50-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
47	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь эдгээр тусгай хамгаалалттай газар нутгуудтай хамтран ажилладаг уу?		
48 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь өөрийн газар нутаг дахь байгалийн өвийг сурталчлах ажлуудыг хийдэг үү?		
49	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь өөрийн газар нутаг дахь геологийн өвийг тус газар нутгийн байгалийн өвийн бусад асуудлуудтай холбосон арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?		
	<b>Соёлын өв (iiA)</b>		
	<b>Соёлын биет өв</b>		
50	Тус геопарк болохоор төлөвлөж буй газарт хамгаалагдсан соёл/түүхийн хөшөө дурсгалт газрууд байдаг уу? <b>Хэрэв тийм бол 51-53-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 54-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
51	Тус геопарк болохоор төлөвлөж буй газарт эдгээр соёл/түүхийн хөшөө дурсгалт газруудтай гэрээ хийж хамтран ажилладаг уу?		
52	дгээр холбогдох соёлын өвийг геопаркын хүрээнд сурталчлах уу?		
53	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь өөрийн газар нутаг дахь геологийн өвийг тус газар нутгийн соёлын өвийн бусад асуудлуудтай холбосон арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?		
	<b>Биет бус өв (iiA)</b>		
54 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газарт соёлын биет бус өв байдаг уу? <b>Хэрэв тийм бол: 55, 56-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 57-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
55	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь биет бус өвөө ашиглаж, сурталчилдаг уу?		
56	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь газар нутгийнхаа биет бус өвийг геологийн өвтэй холбосон сурталчилгаа, ололт нээлт, боловсролын болон бусад үйл ажиллагааг явуулдаг уу?		
	<b>Геологийн процесс, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюул заналтай холбоотой сэдвүүд (iiB)</b>		
57 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюул заналд дасан зохицох, тэдгээрийг бууруулахтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг уу?		
58	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюул заналыг сааруулах чиглэлийн боловсролын арга хэмжээг зохион байгуулдаг уу?		
	<b>Тогтвортой ашиглалтын хэрэгцээ шаардлага (iiC)</b>		

59	Хэрэв тус геопарк болохоор төлөвлөж буй газарт хууль ёсны олборлолт явуулж байгаа бол олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй дэлхийн нөөцийг тогтвортой ашиглах чиглэлд хамтран ажилладаг уу?		
60 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь газар нутгийнхаа байгалийн баялгийн тогтвортой ашиглалтын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийдэг үү?		
<b>Шалгуур iii</b>			
	(iii) ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркууд нь үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрсөн хууль эрх зүйн зохицуулалттай удирдах байгууллагатай байна (iiiA). Удирдах байгууллага нь ЮНЕСКО-ийн дэлхийн геопаркуудын сүлжээнд бүртгэгдсэн газар нутгийг бүхэлд нь удирдан зохицуулахад шаардлагатай эх үүсвэрээр зохих ёсоор тоноглогдсон байна (iiiB).		
	<b>Удирдах байгууллага (iiiA)</b>		
61	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн, хууль эрх зүйн зохицуулалттай удирдах байгууллагатай юу?		
62	Танай геопаркийн шийдвэр гаргах үйл явцад орон нутгийн шийдвэр гаргагчид оролцдог уу?		
63(*)	Удирдах байгууллагад орон нутгийн иргэд, орон нутгийн зохих эрх бүхий байгууллагуудын төлөөлөл байгаа юу?		
	<b>Зохих тоног төхөөрөмж (iiiB)</b>		
64 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь байнгын, мэргэжлийн ажлын албатай юу?		
65 (*)	Тус ажлын албанд тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагтай өдөр тутамд хамтран ажилладаг геологийн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаач багтсан уу?		
66	Тус алба нь олон салбарын төлөөллөөс бүрддэг үү (жишээлбэл боловсролын мэргэжилтэн, соёл, архитектур, антропологи, маркетинг, аялал жуулчлал гэх мэт)?		
67	Тус газарт ирэх дөрвөн жилийн санхүүжилтэд зориулсан тодорхой, бие даасан төсөв байгаа юу?		
68 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь менежментийн төлөвлөгөө эсвэл түүнд зориулсан ерөнхий үзэл баримтлалтай юу?		
<b>Шалгуур IV</b>			
	(iv Өргөдөл гаргаж буй газар нь дэлхийн өв, шим мандлын нөөц газар зэрэг ЮНЕСКО-ийн өөр конвенц болон сүлжээнд бүртгэлтэй юу? Хэрэв тийм бол ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркийн статус нь бие дааж болон бусад хамтын ажиллагаагаар дамжуулан тус газрын үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлэх талаар үндэслэл болон нотолгоо болох мэдээллүүд өгнө үү (ivA).		
	<b>Давхар тодорхойлолтууд (ivA)</b>		
69	Тус газар нутаг нь Дэлхийн өвийн жагсаалт ба/эсвэл шим мандлын нөөц газруудын дэлхийн сүлжээнд бүртгэгдсэн үү. <b>Хэрэв тийм бол : 70-73 асуултыг бөглөнө үү. Үгүй бол: 74-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
70 (*)	ЮНЕСКО-ийн бусад конвенц, сүлжээнд бүртгэлтэй газруудад тус геопарк болохоор төлөвлөж буй газар		



	нутгийн талаар мэдээлэл өгсөн үү. Тус газрууд нь геопаркийн талаарх хөгжил, үзэл баримтлалыг эерэгээр дэмжиж байна уу?		
71 (*)	Тус ЮНЕСКО-ийн бусад конвенц, сүлжээнд бүртгэлтэй газар нь геопаркийн дэлхийн сүлжээнд нэгдэж, тус газрын үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлэх талаар судалж үзсэн үү?		
72	Тус газар нь ЮНЕСКО-ийн бусад конвенц, сүлжээнд бүртгэлтэй газруудтай албан ёсны түншлэлийн гэрээ байгуулсан уу?		
73	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь тодорхой, харагдахуйц, бие даасан шошго, брэндтэй юу?		
74	Тус газар нутаг нь олон улсын/үндэсний тусгай хамгаалалттай газар нутагтай (жишээ нь Рамсар, Байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, Натура 2000 (Европын тусгай хамгаалалттай газар нутгууды сүлжээ)-нд бүртгэгдсэн газар нутагтай давхцаж байгаа юу? <b>Хэрэв тийм бол: 75-77 асуултыг бөглөнө үү. Үгүй бол: 78-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
75 (*)	Тус газар нь бусад конвенц, сүлжээнд бүртгэлтэй газруудтай албан ёсны түншлэлийн гэрээ байгуулсан уу?		
76	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг болон бусад тусгай хамгаалалттай газар нутгууд нь сургалт зохион байгуулж, харилцан туршлага солилцдог уу?		
77	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь тодорхой, харагдахуйц, бие даасан шошго брэндтэй юу?		
<b>Шалгуур v</b>			
	ЮНЕСКО-ийн дэлхийн геопаркууд нь үйл ажиллагаандаа нутгийн иргэд болон уугуул иргэдийг идэвхтэй оролцуулах ёстой байдаг (vA). Орон нутгийн нийгэмлэгүүдтэй хамтран орон нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн хэрэгцээг хангах, тэдний амьдарч буй газар нутаг, ландшафт, соёлын өвөрмөц байдлыг хадгалан хамгаалах хамтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байдаг (vB). Тиймээс холбогдох орон нутгийн болон бүс нутгийн бүх оролцогчид, эрх баригчдын төлөөллийг ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркийн менежмент (vC) -д оролцуулах шаардлагатай. Нутгийн болон уугуул мэдлэг, дадал болон менежментийн тогтолцоог шинжлэх ухааны мэдлэгийн хамт тус газрын төлөвлөлт ба менежмент (vD) -д хамруулах шаардлагатай.		
	<b>Орон нутгийн нийгэмлэгүүд (vA) + (vB)</b>		
78	Тус газар нутгийн иргэд болон орон нутгийн удирдагчид тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн үйл ажиллагаанд албан ёсоор, идэвхтэй, оролцдог уу?		
79	Тус орон нутгийн нийгэмлэгийн төлөөлөл тухайн геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтад орсон уу? Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд орон нутгийн нийгэмлэгийн төлөөлөл оролцдог уу?		
	<b>Нутгийн уугуул иргэд (vA) + (vB)</b>		
80	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт нутгийн уугуул иргэд амьдардаг уу? <b>Хэрэв тийм бол 81, 82-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 83-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
81			

	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн үйл ажиллагаанд нутгийн уугуул иргэд албан ёсоор идэвхтэй оролцдог уу?		
82	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт болон үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог уу?		
	<b>Орон нутгийн болон уугуул иргэдийн мэдлэг, дадал, удирдлагын тогтолцоо</b> <b>Биет бус өв/соёлын өвөрмөц байдал (vD)</b>		
83	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь нутгийн болон уугуул иргэдийн мэдлэг, дадал ба/эсвэл менежментийн тогтолцоотой юу? <b>Хэрэв тийм бол: 84-85 асуултыг бөглөнө үү. Үгүй бол: 86-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
84	Хэрэв тийм бол: Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн биет бус өвийн бүртгэл мэдээлэл (бүрэн бус ч гэсэн) байгаа юу?		
85	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь мэдлэг, дадлага туршлага, менежментээ залуу үеийнхэнд дамжуулан өгөх чиглэлд ажлууд хий дэг үү?		
86	Нутгийн хүн ам нь өөрийн гэсэн уугуул хэл болон/эсвэл аялгуутай юу? <b>Хэрэв тийм бол: 87-88 асуултыг бөглөнө үү. Үгүй бол: 89-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
87	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь тус нутгийн уугуул хэлний зохих хэрэглээг хангах арга хэмжээ авч байна уу?		
88	Хэрэв энэ нь бичгийн хэл бол тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь тус хэлийг самбар, сурталчилгааны материалд системтэйгээр ашигладаг уу?		
89	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь бүс нутгийн/үндэсний/ЮНЕСКО-гийн түвшинд бүртгэгдсэн соёлын биет бус өвийн өвтэй юу? <b>Хэрэв тийм бол: 90-р асуултыг бөглөнө үү. Үгүй бол 91-р асуултад үргэлжлүүлэн хариулна уу.</b>		
90	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь энэхүү бүртгэгдсэн соёлын биет бус өвийг өөрийн нөөц, сургалчилгааны ажил зэрэгт ашигладаг уу ?		
	<b>Шалгуур vi</b>		
	ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудыг дэлхийн геопаркуудын сүлжээний гишүүн байх ёстой бөгөөд тус сүлжээний хүрээнд мэдлэг, туршлагаа хуваалцаж, хамтарсан төсөл хэрэгжүүлэхийг уриалдаг, зөвлөгөөгөө хуваалцах үүрэгтэй байдаг (ViA).		
	<b>Нетворкинг (ViA)</b>		
91 (*)	Геопарк болохоор төлөвлөж буй газрын төлөөлөл бусад улс орнуудын геопаркуудад зочилсон уу?		
92	Геопарк болохоор төлөвлөж буй газар нь үндэсний эсвэл олон улсын түвшинд бусад орнуудын геопарктай харилцаа холбоо/түншлэл бий болгосон уу?		
93	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн төлөөлөл үндэсний, бүс нутгийн эсвэл олон улсын түвшний хурлуудад оролцож байсан уу?		
94	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн төлөөлөл нь ЮНЕСКО/дэлхийн геопаркуудын сүлжээний		



	дэмжлэгтэй зохион байгуулагдсан эрчимжүүлсэн курс эсвэл сургалтад оролцож байсан уу?		
<b>Шалгуур vii</b>			
	ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк нь геологийн өвийг хамгаалахтай холбоотой орон нутгийн болон үндэсний хууль тогтоомжийг хүндэтгэн үзнэ. ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк доторх хамгийн чухал геологийн өвийн газар нутаг нь аливаа хүсэлт гаргахаас өмнө үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан байна (ViiA). Үүний зэрэгцээ, ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркийг геологийн өвийг хамгаалах ажлыг орон нутгийн болон үндэсний хэмжээнд дэмжих хөшүүрэг болгон ашиглах хэрэгтэй. Тус өвийн газрыг удирдах байгууллага нь олдсон чулуужсан олдвор, эрдэс чулуу, өнгөлсөн болон гоёлын чулуу зэрэг геологийн биет зүйлсийг тухайн ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркийн газрын (гарал үүслийг үл харгалзан) "чулууны дэлгүүр"-т худалдаалахад шууд оролцохгүй ба геологийн материалын тогтвортой бус худалдааг бүхэлд нь хориглоно (ViiB). Өвийн газар нутгийн менежментийг хамгийн үр дүнтэй, тогтвортой аргаар удирдан явуулах болон хариуцлагатай үйл ажиллагааг тодорхой болгохын тулд ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк доторх байгалиасаа нөхөн сэргээгдэх боломжтой хэсгээс шинжлэх ухааны болон боловсролын зорилгоор геологийн материалыг цуглуулахыг зөвшөөрч болно. Ийм зорилгод суурилсан геологийн материалын худалдааг онцгой тохиолдолд хүлээн зөвшөөрч болох юм. Харин үүнийг олон нийтэд орон нутгийн нөхцөл байдалтай холбон үндэслэлтэйгээр тодорхойлон тайлбарлаж, хяналт тавьж ажиллана. Энэ асуудлыг ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын зөвлөл тохиолдол тус бүр дээр зөвшилцөн шийдвэрлэнэ.		
	<b>Хамгаалалт (ViiA)</b>		
95	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн нутаг дэвсгэрт хууль бус уул уурхай эсвэл үйл ажиллагаа байдаг уу?		
96	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутгийн геологийн ач холбогдол бүхий газрууд нь хуулиар хамгаалагдсан уу?		
	<b>Геологийн материалын худалдаа (ViiB)</b>		
97	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт эсвэл газар нутгийн ойролцоо чулуужсан олдвор, ашигт малтмал, өнгөлсөн чулуулаг болон гоёл чимэглэлийн чулуулгууд ихэвчлэн зардаг "чулууны дэлгүүр" байдаг уу?		
98 (*)	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг болон тус газрын түнш байгууллагуудын дэд бүтэц дотор геологийн материалын борлуулалт хийдэг ?		
99	Тус геопарк болохоор төлөвлөж буй газар нутагт оролцогч талууд эсвэл түнш байгууллагууд геологийн материал зардаг уу?		
100	Геопарк болохоор төлөвлөж буй газрын удирдлах зөвлөлийн оролцогч талууд эсвэл түншүүд геологийн материал зардаг уу?		
	<b>ЮНЕСКО-ийн Дэлхийн геопаркуудын үйл ажиллагааны удирдамж 5.2</b>		
101	Геопарк болохоор төлөвлөж буй газар нутаг нь сүүлийн нэг жилийн хугацаанд үндэсний түвшинд де факто геопаркийн үйл ажиллагаа явуулж байна уу?		